



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 08 өдөр

Дугаар A/157

Мөрөн сум

Тусгай зориулалтаар ан агнах,
загас барих дуудлага
худалдаа зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21, Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.1, 25 дугаар зүйлийн 25.5, 291 дүгээр зүйлийн 291.1, Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6.1, 8.1 дүгээр зүйлийн 1.23 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын 2024 оны “Тусгай зориулалтаар 2024 онд агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээг тогтоох тухай” 89 дүгээр тогтоол, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн “Чиглэл хүргүүлэх тухай” 01/1339 дугаартай албан бичгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тусгай зориулалтаар агнуурын амьтныг агнах, барих дуудлага худалдаа зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, тусгай зориулалтаар агнуурын амьтан агнах, барих дуудлага худалдаа зохион байгуулах удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тусгай зориулалтаар агнуурын амьтныг агнах, барих тусгай зөвшөөрөл олгох дуудлага худалдааг хууль, журамд нийцүүлэн, ил тод, нээлттэй зохион байгуулж дуудлага худалдааны тайлан мэдээг тайлагнаж ажиллахыг ажлын хэсэг (Б.Оюунтуяа)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-д даалгасугай.



Аймгийн Засаг даргын өдөрүүнээс 07 дүгээр
сарын 28-ны өдрийн 15 дугаар захирамжийн
нэгдүгээр хавсралт

ТУСГАЙ ЗОРИУЛАЛТААР АГНУУРЫН АМЬТНЫГ АГНАХ, БАРИХ ДУУДЛАГА
ХУДАЛДАА ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч :

Б.Оюунтуяа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн
бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

Гишүүдэд:

П.Мөнхжаргал (Байгаль орчин, аялал жууллалын газрын дарга)

Б.Болд (Худалдан авах ажиллагааны газрын дотоод
хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн)

Б.Бат-Оргил (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх
зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Ё.Батсайхан (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө
оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

Х.Энхтуяа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү,
төрийн сангийн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Б.Гал-Эрдэнэ (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө
оруулалтын хэлтсийн мэдээлэл, харилцаа
холбооны хяналтын Улсын байцаагч)

Хөтлөгч: Б.Цэнддэлгэр (Орон нутгийн өмчийн газрын өмчийн
бүртгэл, ашиглалт хариуцсан ахлах мэргэжилтэн)

Тэмдэглэл хөтлөгч: Д.Даваадорж (Байгаль орчин, аялал жуулчлалын
газрын Биологийн төрөл зүйл хариуцсан мэргэжилтэн)

оо

3.1. Дуудлагыг худалдаагаар буулж болгоход ишнийг бий болгасан
наслэтий, ил төвэхийн байгуулла.

3.2. Дуудлагыг худалдаагаар буулж болгоход ишнийг бий болгасан
наслэтий, ил төвэхийн байгуулла.

3.2.1. дуудлагыг худалдаагаар буулж болгоход ишнийг бий болгасан
наслэтий, ил төвэхийн байгуулла.

3.2.2. дуудлагыг худалдаагаар буулж болгоход ишнийг бий болгасан
наслэтий, ил төвэхийн байгуулла.

3.2.3. дуудлагыг худалдаагаар буулж болгоход ишнийг бий болгасан
наслэтий, ил төвэхийн байгуулла.

3.2.4. дуудлагыг худалдаагаар буулж болгоход ишнийг бий болгасан
наслэтий, ил төвэхийн байгуулла.

3.2.5. дуудлагыг худалдаагаар буулж болгоход ишнийг бий болгасан
наслэтий, ил төвэхийн байгуулла.

Байгуулла.

3.6. Ажлын хэсгийн засгийн бичиг олгох

Аймгийн Засаг даргын 20.09.04 дүгээр
сарын 08-ны өдрийн 15 дугаар захирамжийн
хоёрдугаар хавсралт

ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН АН АГНАХ, БАРИХ ЗӨВШӨӨРЛИЙН
ДУУДЛАГА ХУДАЛДАА ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6, 8.1.23-д заасан зөвшөөрлийг дуудлага худалдааны журмаас олгохдоо Амьтны тухай хуулийн 29¹ дүгээр зүйлд тухайлан зааж тодорхойлоогүй харилцааг энэхүү удирдамжаар зохицуулна.

1.2. Тусгай зориулалтын агууллын зөвшөөрлийн дуудлага худалдаа (цаашид “дуудлага худалдаа” гэх)-г зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, дуудлага худалдааны удирдамжийг дуудлага худалдаа эхлэхээс өмнө аймгийн Засаг даргын захирамжаар батална.

1.3. Тус удирдамжийн 1.2-т заасан ажлын хэсэгт аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэс, Хууль эрхзүйн хэлтэс, Санхүү, төрийн сангийн хэлтэс, Орон нутгийн өмчийн газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар тус бүрээс төлөөлөл багтсан 5-9 гишүүнтэй байна. (цаашид “ажлын хэсэг” гэх). Гишүүн тус бүрийн үүрэг хариуцлагыг ажлын хэсгийн дарга чиглүүлж Дуудлага худалдаагаар тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар голлох үүрэгтэй оролцож, удирдан зохион байгуулна.

Хоёр. Дуудлага худалдаа зохион байгуулахад баримтлах зарчим

2.1. Дуудлага худалдааг зохион байгуулахад дараах зарчмыг баримтална.

2.1.1. Дуудлага худалдаанд оруулах агууллын амьтныг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалаар баталсан тооноос хэтрүүлэхгүй байх;

2.1.2. Үнийн саналаа ээлж дараалан тодорхой алхамтайгаар өсгөх;

2.1.3. нээлттэй, ил тод байх;

2.1.4. тэгш, шударга оролцоог хангасан байх.

Гурав. Дуудлага худалдааны хэлбэр, дуудлага худалдаа явуулах дараалал

3.1. Дуудлага худалдааг цахимаар зүүм /zoom/ апплейкшн цаашид (программ гэх) ашиглан нээлттэй, ил тод зохион байгуулна.

3.2. Дуудлага худалдааг дараах дарааллын дагуу явуулна:

3.2.1. дуудлага худалдааны бэлтгэл ажлыг хангах;

3.2.2. дуудлага худалдааны товыг зарлан мэдээлэх;

3.2.3. дуудлага худалдаанд оролцогчдыг бүртгэх, баталгаажуулах;

3.2.4. дуудлага худалдааг эхлүүлэх, дуусгавар болгох;

3.2.5. дуудлага худалдааны ялагчийг зарлах, баталгаажуулах, ялагчтай гэрээ байгуулах;

3.2.6. Ан агнах, барих зөвшөөрлийн бичиг олгох;

Дөрөв. Дуудлага худалдааны бэлтгэл ажлыг хангах

4.1. Тус удирдамжийн 1.3-д заасны дагуу аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг дуудлага худалдааг зохион байгуулахтай холбогдуулан дор дурдсан бэлтгэл ажлыг хийж гүйцэтгэнэ:

4.1.1. Дуудлага худалдаагаар агнах, барих амьтны биологийн нөөц, агууруын нөөц, нөхөн төлжилт, үргжил гэх мэт биологийн үзүүлэлт өмнөх жилүүдийн барьж буцаан тавьсан тул загасны мэдээлэл, ан агууруын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнгийн мэдээллийг үндэслэн хуваарилалт хийх;

4.1.2. Дуудлага худалдааны тов, агнах, барих амьтны хуваарь, багц, дуудлага худалдааны анхны үнэ, дуудлага худалдааны зохион байгуулалт, хэлбэр, хугацаа, дэнчингийн хэмжээг тогтоосон шийдвэрийн төслийг бэлтгэсэн байна.

4.1.3. Хуульд заасан шаардлагад нийцсэн, төрийн байгууллагуудад ашигладаг туршигдсан, программ хангамж ашиглах туршилт хийж хадгалах, баталгаажуулах, зохион байгуулчид болон бүх оролцогчид харилцан хяналт тавих боломж бүхий zoom буюу түүнтэй төстэй программ ашиглана.

4.2. Дуудлага худалдааны бэлтгэл ажлын зардлыг дуудлага худалдааны орлогоос гаргана.

Тав. Дуудлага худалдааны зарыг нийтэд зарлан мэдээлэх

5.1. Дуудлага худалдааны зар (цаашид “зар” гэх)-ыг цахимаар дараах байдлаар нийтэд мэдээлнэ:

5.1.1. Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр;

5.1.2. Аймгийн нутгийн захиргааны байгууллагын цахим хуудсаар;

5.2. Энэ удирдамжийн 5.1-д заасан зард дараах мэдээллийг заавал тусгана:

5.2.1. Дуудлага худалдаагаар агнах, барих амьтныг агуулах, барьж буцаан тавиулах тухай эрх бүхий этгээдийн шийдвэр;

5.2.2. Дуудлага худалдааны хэлбэр, программ хангамж;

5.2.3. Дуудлага худалдаа зохион байгуулах цахим хуудасны мэдээлэл (дуудлага худалдаа явуулах тусгай программ хангамж бүхий), харилцах утасны дугаар;

5.2.4. Дуудлага худалдаанд оруулах агууруын бус нутгийн нэр, агуулах, барьж буцаан тавиулах амьтны зүйлийн нэр, тоо толгой болон тухайн агууруын бус нутгийн нэр, агуулах, барьж буцаан тавиулах амьтны зүйлийн нэр, тоог багцалсан мэдээллийг;

5.2.5. Дуудлага худалдааны босго үнэ;

5.2.6. Дэнчингийн хэмжээ, дэнчин тушаах дансны дугаар, дэнчин төлөх сүүлийн хугацаа;

5.2.7. Гэрээний зүйл;

5.2.8. Дуудлага худалдаанд оролцогчдыг бүртгэх хугацаа;

5.2.9. Дуудлага худалдаа эхлэх, дуусах он, сар, өдөр, цаг;

5.2.10. Дуудлага худалдаа зохион байгуулах аймаг, сум, баг, байр, тоот

5.2.11. Дуудлага худалдааны босго үнийг дээд, доод хязгаар.

Зургаа. Дуудлага худалдаанд оролцогчдыг бүртгэх

6.1. Дуудлага худалдаанд оролцохыг хүссэн этгээд хүсэлтээ энэ удирдамжийн хавсралтад заасан маягтын дагуу үнэн зөв гаргаж khuvsqul.boajg@gmail.com цахим

шуудангийн хаягаар дуудлага худалдааны зар зарлагдсан цагаас эхлэн, дуудлага худалдаа эхлэхээс **24** цагийн өмнө хүртэл хүлээн авна.

6.2. Хуулийн этгээдийн байгууллагыг төлөөлж оролцох тохиолдолд тухайн аж ахуйн нэгж, байгууллагын олгосон нотариатаар батлуулсан итгэмжлэл, иргэний үнэмлэх, эсхүл түүнтэй адилтгах бичиг баримт, байгууллага бол улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, ажилтны үнэмлэх;

6.3. Дэнчин төлсөн баримтын хуулбар;

6.4. Бүртгэлийг дуудлага худалдаа эхлэхээс **24** цагийн өмнө хаана;

6.5. Дуудлага худалдаа явуулах ажлын хэсэг дуудлага худалдаанд оролцогчдын материалыг дуудлага худалдаа явуулахаас 2 цагийн өмнө хааж, дуудлага худалдаа эхлэх цаг болмогц оролцогчдод бичиг баримтын үнэн зөв эсэх болон дэнчин төлсөн байдлыг шалгаж, ирсэн хүсэлтүүдийг оролцогч тус бүрээр нь ялган тавьж бүртгэнэ.

6.6. Бүртгэлийн материалаас ташаа мэдээлэл илэрсэн, эсхүл тухайн дуудлага худалдаанд оролцох хүсэлт биш, шаардлага хангаагүй бичиг баримтыг ирүүлсэн тохиолдолд хянаж үзээд дуудлага худалдаа эхлэхээс 12 цагийн өмнө хүсэлт гаргагчид мэдэгдэж баримт бичгийн болон бусад зөрчлөө арилгах боломж олгоно.

6.7. Ажлын хэсэг хүсэлтийг хүлээн авч, дуудлага худалдааны оролцогч болсон мэдэгдлийг хүсэлт гаргасан цахим хаягаар цахим дуудлага худалдаа явуулах тусгай программ хангамжид нэвтрэх нэр, нууц үг, бусад мэдээллийн хамт оролцогчид хүргүүлнэ.

Долоо. Дуудлага худалдааг явуулах

7.1. Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг дуудлага худалдааг зохион байгуулна.

7.2. Дуудлага худалдаа явуулах ажлын хэсэг нь дарга, дуудлага худалдааны хөтлөгч (зарлагч), тэмдэглэл хөтлөгч гэсэн үүрэг бүхий энэ удирдамжийн 1.3-т заасан бүрэлдэхүүнтэй байна.

7.3. Дуудлага худалдааны явцад үүссэн маргааныг тухайн дуудлага худалдаа явуулах ажлын хэсэг хянан шийдвэрлэнэ.

7.4. Дуудлага худалдаа явуулах ажлын хэсгийн дарга дор дурдсан эрх, үүрэгтэй.

7.4.1. Дуудлага худалдаа явуулах ажлыг бүрэн хариуцах;

7.4.2. Дуудлага худалдаа явуулахад зөвлөх ажилтныг сонгон ажиллуулах;

7.4.3. Дуудлага худалдааны явцын тэмдэглэл, дуу, дүрсний бичлэгийг үнэн зөв, бүрэн хөтлөгдсөн эсэхийг хянаж баталгаажуулан тэмдэглэлд гарын үсгийг зурах;

7.5. Дуудлага худалдааны хөтлөгч дор дурдсан эрх, үүрэгтэй:

7.5.1. Дуудлага худалдаанд оролцогчдыг бүртгэж, хувийн дугаар олгох;

7.5.2. Дуудлага худалдааг товлосон хугацаанд нь эхлүүлэх;

7.5.3. Үнэ хаялцуулах дэгийн дарааллын талаар болон өсгөн хэлэх үнийн хэмжээг зарлаж танилцуулах;

7.5.4. Дуудлага худалдааны явцын тэмдэглэлийг үнэн зөв, бүрэн хөтлүүлэх.

7.5.5. Дуудлага худалдаа явуулах ажлын хэсэг оролцогчдын материалыг шалгасны дараа энэ удирдамжийн 7.5.1-д заасан дугаарыг хуваарилж олгоно;

7.5.6. Хөтлөгч оролцогчдод дуудлага худалдааны журам болон үнэ хаялцуулах дэг, анхааруулах бусад зүйлийг танилцуулна;

7.5.7. Хөтлөгч дуудлага худалдаанд явуулах цахим зохион байгуулалтыг танилцуулж, дуудлага худалдааны өсгөн хэлэх үнийн хэмжээг зарлан, дуудлага худалдаа эхлүүлнэ.

7.5.8. Оролцогч үнийн санал хэлэхэд хөтлөгч тухайн үнийн саналыг 3 удаа давтаж хэлнэ;

7.5.9. Бусад оролцогчид энэ удирдамжийн 7.7.6-д зааснаас дээш үнийн санал хэлээгүй тохиолдолд хөтлөгч “буулаа” гэж хэлээд “нэг”, “хоёр”, “гурав” гэж тоолсны дараа дохио өгч ялагчийг зарлаж, дуудлага худалдаа хаасныг мэдэгдэнэ;

7.6. Дуудлага худалдааны тэмдэглэл хөтлөгч дор дурдсан эрх, үүрэгтэй:

7.6.1. Дуудлага худалдааны явцын тэмдэглэлийг үнэн зөв, бүрэн хөтлөх;

7.6.2. Дуудлага худалдааг товлосон хугацаанд оролцогчдыг цахим хаягт оролцохыг утсаар холбогдож урих, оролцогч 2 дахь удаагаа урихад орж ирээгүй тохиолдолд түүнийг дуудлага худалдаанд оролцохос татгалзсанд тооцож, энэ тухай тэмдэглэлд тусгана;

7.6.3. Цахим худалдааг заасан хугацаанд зогсоосноор оролцогчдоос ирүүлсэн үнийн санал тус бүрийн хугацааг цаг, минут, секундээр бүртгэн тэмдэглэлд тусгана.

Найм. Дуудлага худалдааг эхлүүлэх, дуусгах, дуудлага худалдаанд ялагчийг баталгаажуулах

8.1. Дуудлага худалдаанд оролцохоор бүртгүүлж баталгаажсан оролцогчдод дуудлага худалдаа эхлэхээс 1 цагийн өмнө дуудлага худалдаа эхлэхийг анхааруулж цахимаар, утсаар, мессежээр мэдэгдэл хүргүүлнэ.

8.2. Товлосон цагт дуудлага худалдааг эхлүүлэхэд цахим системд орж ирээгүй оролцогчийг дуудлага худалдаанд оролцохос татгалзсанд тооцож тэмдэглэл үйлдэж, дуудлага худалдааг эхлүүлнэ.

8.3. дуудлага худалдаанд хэчинээн ширхэг, тоо толгой, ямар төрөл зүйл ан амьтан, загасны тусгай зөвшөөрөл оруулж байгааг танилцуулж оролцогчдоос анхны үнийн санал хэлснээр дуудлага худалдааг хүчин төгөлдөр болсонд тооцно.

8.4. Оролцогчид босго үнэ дээр өмнөх оролцогчийн өгсөн үнийн өсөн нэмэгдэх үнийн дүн дээр өсгөн нэмэгдүүлэх зарчмаар үнийн үнийн санал хэлж өрсөлдөх;

8.5. Зохион байгуулагчаас тухайн дуудлага худалдааны ялагчийг зарлаж дуудлага худалдааг хааж, дараагийн дуудлага худалдааг эхлүүлнэ.

8.6.Дуудлага худалдааг тухайн өдрийн ажлын цагт эхлүүлж ажлын цагт хааж, дараагийн өдөр мөн ажлын цагт эхлүүлж ажлын цагт хаах зарчмаар явуулна.

8.7. Тусгай зориулалтаар ан агнах, барих амьтны зөвшөөрлийн дуудлага худалдааны босго үнийн хэмжээ нь тухайн амьтны экологи-эдийн засгийн үнэлгээний 20 хувь, дуудлага худалдаанд өсгөх доод хэмжээ нь босго үнийн 10 хувиас доошгүй, өсгөх дээд хэмжээ нь 50 хувиас дээшгүй байх

Тусгай зориулалтын ан	Экологи-эдийн засгийн үнэлгээ МУ-ын ЗГ-ын 2023 оны 260 дугаар тогтоол /төгрөгөөр/	Босго үнэ МУ-ын ЗГ-ын 2023 оны 261 дүгээр тогтоол /төгрөгөөр/	Доод хязгаар /төгрөгөөр/	Дээд хязгаар /төгрөгөөр/
-----------------------	---	---	--------------------------	--------------------------

Тул загас	408,000	81,600	8,160	40,800
Халиун буга	12,700,000	2,540,000	254,000	1,270,000
Бор гөрөөс	645,000	129,000	12,900	64,500
Бусад загас /зэвэг/	29,000	5800	580	2900

8.8. Хуульд заасан үндэслэлээр дахин дуудлага худалдаа явуулахаар бол энэхүү удирдамжийг мөрднө.

8.9. Хуульд зааснаас бусад үндэслэлээр дуудлага худалдааг хүчингүй болгох, дахин дуудлага худалдаа явуулахыг хориглоно.

8.10. Дуудлага худалдаа бүрэн дууссанаас хойш ажлын 2 хоногт багтааж хуульд заасан хугацаанд төлбөрөө төлсөн баримт, ажлын хэсгийн тэмдэглэл зэргийг үндэслэн дуудлага худалдаанд ялагчийг аймгийн Засаг даргын захирамжаар баталгаажуулна.

8.11. Дуудлага худалдааны ялагч нь агуулчлалын газартай байгуулна. Амьтны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.1 дэх заалтыг баримтлан гэрээг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газартай байгуулна.

8.12. Дуудлага худалдааны ялагч нь агуулчлалын газартай байгуулна. Амьтны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.1 дэх заалтыг баримтлан гэрээг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газартай байгуулна.

8.13. Дуудлага худалдааны ялагч нь агуулчлалын газартай байгуулна. Амьтны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.1 дэх заалтыг баримтлан гэрээг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газартай байгуулна.

8.14. Дуудлага худалдааны ялагч нь ажлын 3 өдөрт багтаан үлдэгдэл төлбөрөө төлөөгүй бол дэнчинг буцаан олгохгүй бөгөөд дараагийн үнийн санал хэлсэн иргэн хуулийн этгээдэд санал болгоно.

8.15. Хуульд зааснаас бусад үндэслэлээр дуудлага худалдаанд ялагчийг тодруулах, баталгаажуулах болон эс батлагаажуулах үйлдэл гаргахыг хориглоно.

Ес. Дуудлага худалдааны ялагчтай гэрээ байгуулах, зөвшөөрөл олгох

9.1. Дуудлага худалдааны ялагчийг баталгаажуулсан өдрөөс хойш ажлын 3 хоногийн дотор дуудлага худалдааны ялагчтай гэрээ байгуулна.

9.2. Дуудлага худалдааны ялагчид дараах бичиг баримтын бүрдлийг үндэслэл болгон ан агнах, барих тусгай зөвшөөрлийн бичиг олгоно. Үүнд:

9.2.1. Албан бичгээр ирүүлсэн хүсэлт.

9.2.2. Энэхүү удирдамжийн 8.11, 8.12, 8.13-д заасан гэрээний хуулбар

9.2.3. Дуудлага худалдааны төлбөрийг бүрэн төлсөн баримт

9.2.4. Агуулчлалын нөөц ашигласны төлбөрийн 50 буюу түүнээс дээш хувийг төлсөн баримт /Засгийн газрын 2017 оны 339 дүгээр тогтоолоор батлагдсан “Тусгай төлбөртэйгөөр агууллах агуулчлалын амьтны олзворын жишиг үнэ, төлбөр, хураамжийн хэмжээ”-г баримтлан төлбөрийг төлөх/

9.2.5. Агуулчлалын нөөц ашигласны хураамж 100 хувь төлсөн баримт

9.2.6. Анчин, загасчны паспортын хуулбар зэрэг бичиг баримтуудыг цахимаар хүлээн авч ан агнах, загас барих зөвшөөрлийн хүсэлт ирүүлсэн өдрөөс хойш ажлын 2 хоногт багтаан олгоно.

Арав. Дуудлага худалдааны үнэ, дэнчин

10.1. Дуудлага худалдааны дэнчин нь Засгийн газрын тогтоолоор баталсан босго үнийн 10 хувиар тооцно

10.2.Дэнчинг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын татварын бус орлогын 100170013401 Хө.БОАЖГазар н.с дансанд байршуулна.

10.3.Дуудлага худалдааны ялагчаас бусад оролцогчдын дэнчинг дуудлага худалдаа болсон өдрөөс хойш ажлын З хоногийн дотор аливаа шимтгэлгүйгээр буцаан олгоно.

Арван нэг. Дуудлага худалдааны орлогыг тайлагнах, зарцуулах

11.1.Дуудлага худалдаанаас орох орлогын 50 хувийг Байгаль орчны уур амьсгалын сангийн 100900013441 тоот дансанд, 50 хувийг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын татварын бус орлогын 100170013401 Хө.БОАЖГазар н.с дансанд байршуулж аймгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлэх болон дуудлага худалдаа зохион байгуулах зардалд зарцуулна.

11.2.Дуудлага худалдааны орлогоос дуудлага худалдаа зохион байгуулах бүх зардлыг шийднэ.

Арван хоёр. Маргаан шийдвэрлэх

12.1.Дуудлага худалдааны явцад үүссэн маргааныг дуудлага худалдаа явуулах ажлын хэсэг шийдвэрлэнэ.

12.2.Аж ахуйн нэгж, байгууллага дуудлага худалдаатай холбогдсон гомдлыг ажлын З өдөрт багтаан тухайн шатны Засаг дарга болон шүүхэд тавьж шийдвэрлүүлэх эрхтэй.

--- 000 ---